



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2006 оны 08 сарын 07 өдөр

Дугаар 277

Улаанбаатар 401

Гадаадад суралцуулах тухай

"Өндөр хөгжилтэй орны их сургуульд Засгийн газрын тэтгэлгээр хүн суралцуулах асуудлыг зохицуулах зөвлөл"-ийн 2006 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн хурлын тэмдэглэл, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын 2,6-г үндэслэн ТУШААХ нь:


1. Хүрэлсүх овогтой Халиуныг Австралийн Deakin их сургуулийн Сингапур улс дахь салбар сургуульд худалдааны чиглэлээр, Өвгөнхүү овогтой Хангайхүүг ХБНГУ-ын Тюбинген хотын их сургуульд, Бат-Эрдэнэ овогтой Баасанжаргалыг Англи улсын Northumbria их сургуульд, Бат-Эрдэнэ овогтой Түмэнбаясгаланг Канад улсын Монктон нислэгийн коллежийн мэргэжлийн нисгэгчийн ангид, Бямбажав овогтой Ганбатыг Англи улсын Commonwealth хуулийн сургуулийн магистрантурт тус тус 2 жилийн хугацаагаар, Чулуун овогтой Намжилдоржийг Австри улсын Вена хотын Газар тариалангийн их сургуулийн докторантурт, Ринчинхорлоо овогтой Мөнхтулгыг ОХУ-ын ШУА-ийн Санкт-Петербург хотын салбарын Хэл шинжлэлийн хүрээлэнгийн аспирантурт тус тус 3 жилийн хугацаагаар 2006-2007 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

2. Австрали улсын James Cook их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр суралцаж буй Балдандорж овогтой Цэгмидийн суралцах хугацааг 0.5 жилээр сунгасугай.

3. ОХУ-ын Москва хотын Хүнсний үйлдвэрийн их сургуулийн докторантурт суралцаж буй Дорж овогтой Цэцгээ, ОХУ-ын ШУА-ийн Хэл шинжлэлийн хүрээлэнгийн аспирантурт суралцаж буй Дүгэрсүрэн овогтой Аюуш нарын эрдэм шинжилгээний ажлын хамгаалалтын зардлыг тус тус зээлээр олгосугай.

4. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.

5. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2006 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 71 дүгээр тушаалын Бямбажав оровтой Ганбаттай холбогдолтой хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.



Ө.Энхтүвшин

7/1. Тушаалд кодификаци хийгдэв.

Ө.ЭНХТҮВШИН